

ПИТЕР МОРРОУГИЙН НЭРЭМЖИТ “ХАСБАНКНЫ ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР” /2022-2023/

Питер Морроу нь 2015 оны 7 дугаар сараас ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байсан бөгөөд түүний Монгол Улсын банк, санхүүгийн салбар төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмэр, дурсгалыг хүндэтгэн энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг бид 7 дахь удаагаа уламжлал болгон зарлаж байна.

Тэтгэлгийн зорилго:

Банк, санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, дата аналит, мэдээллийн технологийн чиглэлээр амжилттай суралцаж буй, цаашид арилжааны банкинд ажиллах хүсэл сонирхолтой чадварлаг, өсөх ирээдүйтэй оюутнуудыг нээн илрүүлж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажлын гараагаа оновчтой, зөв эхлүүлэхэд нь туслах.

Тэтгэлэгт дараах зүйлс багтана:

- ✓ 2 сая төгрөгийн сургалтын төлбөр
- ✓ Хасбанканд дадлага хийх боломж

Тэтгэлэгч хүсэгч оюутанд тавигдах ерөнхий шаардлага:

- ✓ Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 3 болон 4 дүгээр дамжааны өдрийн ангийн оюутан;
- ✓ Сурлагын голч дүн 3.0 -аас дээш;
- ✓ Нийгэм, олон нийтийн ажил, арга хэмжээнд идэвхтэй оролцдог;
- ✓ Оюутны эрдэм шинжилгээний хурал, илтгэл, уралдаан тэмцээнд амжилт гаргасан бол давуу тал болно;

Бүрдүүлэх материал:

- ✓ Тэтгэлэг хүсэгчийн анкет /анкетыг **эндээс** татаж авна уу/;
- ✓ Сургуулийн тодорхойлолт, дүнгийн баталгаат хуулбар;
- ✓ Суралцсан хугацаанд үзүүлсэн амжилт, шагналын хуулбар;
- ✓ Иргэний үнэмлэхний хуулбар;
- ✓ Өөрийнхөө тухай болон яагаад уг тэтгэлэгт хөтөлбөрт хандаж байгаагаа илэрхийлсэн видео бичлэг /max 2 мин/;

Жич: Файлын хэмжээнээс хамааран мэйл ирэхгүй байж болзошгүй тул материалуудаа google drive болон youtube сувагт байршуулан, хандах эрхтэйгээр холбоосыг илгээх боломжтой.

Материал хүлээн авах хугацаа:

Материал хүлээн авах хугацаа: 2022.11.19-ний өдрийн 18:00 цаг хүртэл

Тэтгэлэг хүсэгчийн материалыг зөвхөн recruiter@xacbank.mn имэйл хаягаар хүлээн авна.

Сонгон шалгаруулалтын үе шат:

1-р шатны сонгон шалгаруулалт: Анкетийн сонгон шалгаруулалт

2-р шатны сонгон шалгаруулалт: Шилдэг контент болон илтгэлүүдийг шалгаруулах

3-р шатны сонгон шалгаруулалт: Ярилцлага болон шилдэг оюутан шалгаруулах

Шилдэг оюутанд тэтгэлэг гардуулах
ХасБанкны тэтгэлэгт оюутан шагнал гардуулах

Холбоо барих:

Төв банкны 7577-1888 /дотуур дугаар 802/,

Материалаа илгээх хаяг: recruiter@xacbank.mn

Шалгаруулалтын дүнг зарлах:

Эцсийн шатанд шалгарсан 5 оюутныг ХасБанкны www.xacbank.mn цахим хуудсаар мэдээлж, тэтгэлэг олгоно.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС